

СУРГАЛТ, СУДАЛГААНЫ ОРЧИН НӨХЦӨЛ

Тус хүрээлэн нь мэдээлэл харилцааны технологи, инновацийн суурин, орчин үеийн тоног төхөөрөмж бүхий хурлын танхим, сургалтын танхим, зайндын сургалтын вебинар өрөө, лингафоны танхимтай, сургалтыг цаг хугацаа орон зайн хамааралгүй зохион байгуулах боломжтой.

ХУРЛЫН ТАНХИМ



СУРГАЛТЫН ТАНХИМ 1



СУРГАЛТЫН ТАНХИМ 2

ЛИНГАФОНЫ ТАНХИМ



ВЕБИНАР
СУРГАЛТЫН ӨРӨӨ

АЛБАНЫ БАЙР

НОМЫН САН

“СУРГАЛТЫН ЦАХИМ СИСТЕМ”
[/WWW.SURGALT.PROKUROR.MN/](http://WWW.SURGALT.PROKUROR.MN/)

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГЫГ QR КОД
УНШУУЛАН ЦАХИМ ХЭЛБЭРЭР ТАНИЛЦАХ
БОЛОМЖТОЙ.



Улсын ерөнхий прокурорын газрын
дэргэдэх Сургалт, судалгааны
хүрэээн

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот
14210, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр
хороо Чинван Г.Чагдаржавын гудамж

Утас: 70143344

Цахим шуудан: gpo_tri@prokuror.mn



УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН
ГАЗРЫН ДЭРГЭДЭХ СУРГАЛТ,
СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН

СУРГАЛТ
СУДАЛГААНЫ
ХҮРЭЭЛЭН

ХҮРЭЭЛЭНГИЙН ТУХАЙ

Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэн нь шинжлэх ухааны болон прокурорын хяналтын ажлын чиглэлээр судалгааны ажил хийж гүйцэтгэх, прокурор, ажилтнуудад зориулсан сургалтыг зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй.

ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Сургалтын нэгдсэн тогтолцоог бий болгож, эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомж, эрх зүйн шинэтгэлийн чиг хандлагатай уялдуулан сургалтыг зохион байгуулах, прокурорын байгууллагаас хийх судалгааны үндсэн болон тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, прокурор, ажилтнуудын судалгааны арга зүйн мэдлэг, чадварыг сайжруулах, судалгааны ажлын чанар, үр нөлөөг нэмэгдүүлэх үүднээс Сургалт, судалгааны талаар баримтлах үзэл баримтлалыг батлан хэрэгжүүлж байна.

АЛСЫН ХАРАА

Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын хэмжээнд тэргүүлэх байр суурьтай, жишиг сургалт, судалгааны тогтолцоог бүрдүүлнэ.

ЭРХЭМ ЗОРИЛГО

- Эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэхдээ хүний эрх, шударга ёсиг эрхэмлэж, хуулийг нэг мөр хэрэглэх мэргэжлийн ур чадвар бүхий прокурор, ажилтныг төлөвшүүлж хөгжүүлнэ.
- Прокурорын байгууллагын судалгааны ажилд шинжлэх ухаан, технологи, инновацийн дэвшилийг нэвтрүүлж, чанар, үр нөлөөг нэмэгдүүлэхэд оршино.



ЧИГ ҮҮРЭГ

СУРГАЛТЫН АЛБА

- Прокурорын байгууллагын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;
- Прокурор, ажилтны томилогохын өмнөх болон үргэлжилсэн, давтав сургалтыг зохион байгуулах;
- Сургалтын хөтөлбөрүүдийг магадлан итгэмжлүүлж, дангаар болон бусад байгууллагатай хамтран сургалт зохион байгуулах;
- Мэргэжлийн ур чадвар, гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх сургалт зохион байгуулах;
- Мэргэжлийн уралдаан, тэмцээн зохион байгуулах;
- Прокурорын байгууллагын сургач багшиг бялтгах.



СУДАЛГААНЫ АЛБА

- Эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилт, боловсронгуй болгох чиглэлээр судалгаа хийх, зөвлөмж, дүгнэлт боловсруулах;
- Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх, прокурорын хяналтын чиглэлээр аргачлал боловсруулах;
- Прокурорын байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр онол, арга зүйн судалгаа хийх, зөвлөмж, дүгнэлт боловсруулах;
- Эрдэм шинжилгээний бүтээл, нийтлэл, өгүүлэл гаргах нийтгүүлэх;
- Эрдэм шинжилгээ онол, практикийн бага хурал зохион байгуулах.



ТАМГЫН ХЭЛТЭС

- Прокурор, ажилтны үйл ажиллагаагаа хэвийн явуулах, ажлын байр, суралцах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч, хэрэгжүүлэх;
- Захиргаа, үйлчилгээний ажилтнуудын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, зохион байгуулах;
- Ажлын байр болон суралцах нарны байрлах албаны байрны ашиглалтын үйл ажиллагаанд хяналт тавих, холбогдох арга хэмжээ авах;
- Бусад.

ХАМТЫН АЖИЛЛАГАА

САНАМЖ БАЙГУУЛАН ХАМТРАН АЖИЛЛАЖ БУЙ БАЙГУУЛЛАГУУД



БУСАД БАЙГУУЛЛАГА

Улсын Дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн, Хүний эрхийн үндэсний комисс, Монголбанкны Санхүүгийн мэдээллийн алба, Санхүүгийн зохицуулах хороо, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба, Мердөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагууд, Шүүх шинжилгээний ерөнхий газар, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монголын Хуульчдын холбоо, Монголын Нотариатчдын танхим, Шинжлэх ухааны академи, Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургууль, Удирдлагын академи, Дотоод хэргийн их сургууль, Шихихутуг их сургууль зэрэг 30 орчим байгууллагатай хамтран ажиллаж байна.

ОЛОН УЛСЫН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР

Азийн сан, Азийн хөгжлийн банк, Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага (IDLO), КОЙКА олон улсын байгууллага, Дэлхийн байгаль хамгаалах сан, Эмнести интернэшил, Ханис-Зайделийн сангийн Монгол Улс дахь төлөөлөгчийн газар, Францын магистратын үндэсний сургууль зэрэг 20 орчим олон улсын төсөл, хөтөлбөр, байгууллагатай хамтран ажиллаж байна

